

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАТЛАВ:

ТАМГЫН ДАРГА



Ц.ГАНБОЛД

Огноо: 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр

“МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ДҮГНЭЛТ ГАРГАХ” ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
БАРИМТ БИЧИГ

Шинжээч сонгох урилгын дугаар: № 03-07

УЛААНБААТАР ХОТ

2021 он

## ШИНЖЭЭЧ СОНГОХ УРИЛГА

Дугаар 03-07

Үндэсний аудитын газар нь "Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах" аудитад шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам"-ын хүрээнд хэрэгжих болно.

Шинжээчийг сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:

- Ажлын даалгавар
- Саналын жишиг баримт бичиг
- Гэрээний ерөнхий, тусгай нөхцөл

Шинжээч нь ҮАГ-АД/21-021 дугаартай ажлын даалгаварт тусгагдсаны Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийх болон Аудитын хоёрдугаар газрын аудитын багийн бүрэлдэхүүнд орж дараах чиглэлүүдээр судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, туслах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэх ба байгууллага дээр холбогдох багийн хамт очиж аудитыг гүйцэтгэнэ.

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улсын төсвийн, Орон нутгийн, Эрүүл мэндийн даатгалын сангийн, Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн холбогдох бусад материалыг хамруулж ажиллах бөгөөд ажлын 22 хоногт багтаан гүйцэтгэнэ. Үүнд:

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба Түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай. /Гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үүргийг тусгасан байна/

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг доорх хаягаар авч болох ба саналаа 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү. Хугацаа хоцорсон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Нэмэлт мэдээллийг авч болох албан тушаалтан: Аудитын хоёрдугаар газрын Аудитын менежер Д.Энхдалай. Ажлын утас: 260512, гар утас: 99017209

Саналыг дараах цахим хаягаар /нэгтгэсэн pdf файл хэлбэрээр/ ирүүлнэ үү.

Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Ажлын утас: 263533, гар утас: 88051068, Аудитын хоёрдугаар газрын Аудитын менежер Д.Энхдалай. enkhdaid@audit.gov.mn

Захиалагчийн хаяг: Үндэсний аудитын газар. 15160 Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, 04 дүгээр давхар, Утас 26 35 33, www.audit.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З. Руу

Ц.НАРАНЧИМЭГ

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ШИНЖЭЭЧИЙН  
АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 147-А2/1  
/21-021

Улаанбаатар хот

**Ажлын зорилго:** Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитын ажил үүргийг гүйцэтгэх.

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ:**

“Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн “Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д хийх аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу ажил гүйцэтгэх, шаардлагад нийцсэн мэргэшсэн, ажлын туршлага бүхий мэргэжлийн зөвлөх шинжээчийг аудитад оролцуулна.

**ХОЁР. ЗОРИЛГО**

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд судалгаа, дүн шинжилгээ хийх, мэргэжлийн дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах, аудиторуудад арга зүйн зөвлөгөө өгөхөд энэхүү ажлын зорилт оршино.

**ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ**

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийх болон Аудитын хоёрдугаар газрын аудитын багийн бүрэлдэхүүнд орж дараах чиглэлүүдээр судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, туслах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 3.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн сүүлийн 5 жилээр судалгаа, дүн шинжилгээ хийх;
- 3.2 Нэгдсэн төсвийн орлого, орлогын төрөл, төсөвлөлт, бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх;
- 3.3 Төсвийн зардал /тэвчиж болох зардал/-ын гүйцэтгэл, Ковид-19 цар тахлын үеийн төсвийн зарцуулалтын талаар дүн шинжилгээ хийх;
- 3.4 Хөрөнгө оруулалтын зардал, “Алсын хараа 2050”, Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх;
- 3.5 Аудитын дунд үндэслэн санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;
- 3.6 Аудитын багт арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хийнэ.

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Аудитын хоёрдугаар газрын захирал, аудитын менежер болон ахлах аудиторын өгсөн чиглэл, арга зүйн дагуу аудитыг гүйцэтгэнэ.

Аудитын явцад олж авсан мэдээллийг төрийн аудитын үйл ажиллагаанд ашиглахаас өөр зорилгоор хөндлөнгийн этгээдэд дамжуулах, хувийн буюу бусдын ашиг сонирхлын төлөө ашиглуулах эрхгүй бөгөөд мэдээллийн нууцыг чанд хадгална.

Мэргэжлийн зөвлөх шинжээч аудитын ажлыг гэрээний хугацаанд багтаахын тулд илүү цагаар ажиллана.

## ДӨРӨВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитыг гүйцэтгэх Аудитын хоёрдугаар газрын аудитын багийн бүрэлдэхүүнд орж ажиллах ба байгууллага дээр багийн хамт очиж аудитыг гүйцэтгэнэ.

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улсын төсвийн, Орон нутгийн, Эрүүл мэндийн даатгалын сангийн, Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн холбогдох бусад материалыг хамруулна.

### ТАВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан зорилгыг хэрэгжүүлж, ажил үүргийн хуваарийн дагуу хамрах хүрээний ажлыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-д нийцүүлэн гүйцэтгэж, аудитын гүйцэтгэлийн үе шатанд судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол хийж, тайлагналын үе шатанд аудитын тайлан бичиж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулах бөгөөд ажлын баримтыг аудитын багт хүлээлгэж өгнө.

Ажлын даалгаварт заасан ажил үүргийг ахлах аудитор, аудитын менежер, газрын захирал, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн өгсөн чиглэлийн дагуу тухай бүр чанартай, түргэн шуурхай гүйцэтгэж, аудитын дүгнэлт, зөвлөмж, ажлын тайлан бэлтгэсэн байна.

### ЗУРГАА. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд аудитыг гүйцэтгэж байгаа мэргэжлийн зөвлөх шинжээч нь Аудитын хоёрдугаар газрын аудитын багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан мэргэжлийн зөвлөх шинжээч нь ажил эхлүүлэх болон хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлж, захиалагч /Үндэсний аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Аудитын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн бол тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

### ДОЛОО. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь аудитын гүйцэтгэх үе шатнаас эхлэн тайлагнах үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

**Аудитын эхлэх хугацаа:** 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, **дуусах хугацаа:** 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байх ба Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг УИХ-аар хэлэлцүүлэх үе шатанд шаардлагатай бол аудитын тодруулга, тайлбар бэлтгэж ирүүлнэ.

## НАЙМ.ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Үндэсний аудитын газартай хамтран ажиллахад ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байх бөгөөд иж бүрэн түншлэлийн чиглэлээр хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд мэргэжлийн зөвлөх шинжээч нь

- Тесвийн төсөл, тесвийн гүйцэтгэлээр макро түвшний судалгаа, дүн шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй;
- Санхүү, эдийн засгийн чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой;
- Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгтэй.

### ЕС . ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Мэргэжлийн зөвлөх шинжээчийн ажлын хэлсийг харилцан тохиролцож гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоно.

### АРАВ. АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Ажлын цагийн<br>үзүүлэлтүүд | 1-р долоо<br>хоног<br>/V.13-V.14/ | 2-р долоо<br>хоног<br>/V.17-V.21/ | 3-р долоо<br>хоног<br>/V.24-V.28/ | 4-р долоо<br>хоног<br>/V.31-VI.04/ | 5-р долоо<br>хоног<br>/VI.08-VI.18/ | Нийт |
|-----------------------------|-----------------------------------|-----------------------------------|-----------------------------------|------------------------------------|-------------------------------------|------|
| Ажиллах хоног               | 2                                 | 5                                 | 5                                 | 4                                  | 7                                   | 22   |
| Өдөрт ажиллах цаг           | 8                                 | 8                                 | 8                                 | 8                                  | 8                                   | 176  |
| Аудитын<br>үе шат           | Төлөвлөх                          |                                   |                                   |                                    |                                     |      |
|                             | Гүйцэтгэх                         |                                   |                                   |                                    |                                     |      |
|                             | Тайлагнах                         |                                   |                                   |                                    |                                     |      |

### АЖЛЫН ДААЛГАВРЫГ

#### ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Г.Чандзор*  
2021.04.26

/Ш.ҮНЭНТӨГС/

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Б.Бундхорол*  
/Б.БУНДХОРОЛ/

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Оюунгэрэл*  
/С.ОЮУНГЭРЭЛ/

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Я.Самбууням*  
/Я.САМБУУНЯМ/

#### БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

*Д.Энхдалай*

/Д.ЭНХДАЛАЙ/

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР

*Б.Баттогтох*

/Б.БАТТОГТОХ/

## **БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ**

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 10-ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

## САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

| № | Ерөнхий зүйл   |
|---|--|
| 1 | Захиалагч нь: [Үндэсний аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.   |
| 2 | Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж:<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба Аудитын хоёрдугаар газрын холбогдох багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг авч ажиллана.  |
| 3 | Шинжээчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай: "тийм" эсвэл "үгүй" [үгүй]   |
| 4 | Санал хүлээн авах хугацаанаас 2 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө. [Үндэсний аудитын газрын Захиргаа, удирдлагын газар.<br>Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш <a href="mailto:tsend-ayushn@audit.gov.mn">tsend-ayushn@audit.gov.mn</a> . Ажлын утас 263533. Гар утас: 88051068 ]  |
| 5 | Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.   |
| 6 | Хураангуй жагсаалтад орсон шинжээч эсхүл хуулийн этгээд мөн жагсаалтад орсон бусад компанийтай хамтран ажиллаж болно: /хамааралгүй/  |
| 7 | 1. Шинжээчийн үйлчилгээг гүйцэтгэхэд ажлын 22 хоногийн мэргэжлийн үйлчилгээ шаардагдана.<br>2. Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийх болон Аудитын хоёрдугаар газрын аудитын багийн бүрэлдэхүүнд орж дараах чиглэлүүдээр судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, туслах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:<br>- Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн сүүлийн 5 жилээр судалгаа, дүн шинжилгээ хийх;<br>- Нэгдсэн төсвийн орлого, орлогын төрөл, төсөвлөлт, бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх;<br>- Төсвийн зардал /тэвчиж болох зардал/-ын гүйцэтгэл, Ковид-19 цар тахлын үеийн төсвийн зарцуулалтын талаар дүн шинжилгээ хийх;<br>- Хөрөнгө оруулалтын зардал, "Алсын хараа 2050", Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх;<br>- Аудитын дунд үндэслэн санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;<br>- Аудитын багт арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хийнэ. |
| 8 | Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: Дээд хязгаар нь 3 520 000 /гурван сая таван зуун хорин мянган төгрөг/ байна.  |
| 9 | Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх, шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн дараах үндсэн мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ. Үүнд:<br>- Оролцох хүсэлтийн маягтаар саналыг баталгаажуулж ирүүлэх. /Маягт 2/<br>- Оролцогчийн танилцуулга. /Маягт 3/  |

|    |   |
|----|---|
|    | <ul style="list-style-type: none"> <li>- Санал болгож буй мэргэжилтний намтар(CV). /Маягт 4/</li> <li>- Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж. /Маягт 5/</li> <li>- Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт. /Маягт 6/</li> <li>- Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга /Маягт 7/</li> </ul> <p><b>Дараах нэмэлт мэдээллийг хавсарган ирүүлнэ.</b></p> <p><b>Хуулийн этгээд бол:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /холбогдох тусгай зөвшөөрөлтэй бол/;</li> <li>- Татварын өргүй тухай тодорхойлолт /цахим/ ;</li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /цахим/;</li> <li>- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээллийг нотлох баримтаар ирүүлэх. Сүүлийн 3 жилээр /2018,2019,2020 он/;</li> <li>- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>- Санхүүгийн тайлан. Сүүлийн 2 жилээр. /2019, 2020 оны жилийн эцсийн/.</li> </ul> <p><b>Хувь хүн/баг бол:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэний үнэмлэхийн хуулбар;</li> <li>- Анкет /CV/;</li> <li>- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;</li> <li>- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний нотлох баримт ирүүлэх. /сүүлийн 3 жилээр 2018,2019,2020 он/;</li> <li>- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ.<br/>/Холбогдох тодорхойлолт, албан мэдэгдэл нь тухайн сонгон шалгаруулалтыг зарласан цаг хугацаанд хамааралтай байна/</li> </ul> <p><b>Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:</b></p> <p>Мэргэжлийн зөвлөх шинжээч нь Үндэсний аудитын газартай хамтран ажиллахад ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байх бөгөөд иж бүрэн түншлэлийн чиглэлээр хамтран ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлээр макро түвшний судалгаа, дүн шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;</li> <li>- Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй;</li> <li>- Санхүү, эдийн засгийн чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой;</li> <li>- Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгтэй.</li> </ul> |
| 10 | Шинжээчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.   |
| 11 | <p>Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага</p> <p>Нууцлал: Шинжээч нь ажлын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дурмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.</p> <p><b>Ажлын даалгаварт тусгагдсан бусад</b></p>   |

|    |   |
|----|---|
| 12 | Татвар [Холбогдох татвар, төлбөр хураамж нь санал болгосон үнэд багтсан байна]:   |
| 13 | Санал ирүүлэх тоо: эх хувь 1 /цахим PDF файлаар/ ирүүлнэ.   |
| 14 | <p>Санал ирүүлэх хаяг: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. <i>tsend-ayushn@audit.gov.mn</i>. Гар утас: 88051068 ]</p> <p>Үндэсний аудитын газар.15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр. 04 дүгээр давхар 409 тоот Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Ажлын утас 263533.</p> <p>Аудитын хоёрдугаар газрын Аудитын менежер Д.Энхдалай.<br/> <i>enkhdalaid@audit.gov.mn</i></p> |
| 15 | Саналыг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлсэн байна.   |

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г \_\_\_\_\_ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: \_\_\_\_\_

Холбоо барих утас: \_\_\_\_\_

## ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

### 3.1. Ерөнхий танилцуулга

.....  
.....  
**(Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)**

### 3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

*Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. /нотлох баримт ирүүлэх шаардлагатай/*

|   |                      |  |
|---|----------------------|--|
| Гүйцэтгэсэн ажлын нэр:  |                      | Улсын нэр:   |
| Байршил:  |                      | Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):              |
| Захиалагчийн нэр:   |                      | Ажилтны тоо:   |
| Хаяг:   |                      | Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:                        |
| Эхэлсэн он сар өдөр:  | Дууссан он сар өдөр: | Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:                        |
| Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):   |                      | Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо: |
| Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд: |                      |  |
| Төслийн талаарх товч танилцуулга:   |                      |  |
| Төслийн хурээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:                |                      |  |

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: \_\_\_\_\_

## САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг төвч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшийн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшийн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муюу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

МАЯГТ 5

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ<sup>1</sup>

| № | Нэр             | Хаяг, байршил | Хүчин чадал |
|---|-----------------|---------------|-------------|
| 1 | Ажлын байр      |               |             |
| 2 | Тоног төхөөрөмж |               |             |

МАЯГТ 6

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

| № | Нэр | Албан тушаал | Хариуцах ажил |
|---|-----|--------------|---------------|
|   |     |              |               |
|   |     |              |               |
|   |     |              |               |
|   |     |              |               |
|   |     |              |               |

МАЯГТ 7

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

/Баталгаажуулалт/

<sup>1</sup> Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.

## I. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

|                               |  |
|-------------------------------|--|
| 1.1 Нэр томъёоны тайлбар      | Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:  |
|                               | (а) "Гэрээнд хэрэглэх хууль" гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.   |
|                               | (б) "Гүйцэтгэгч" гэж захиалагч, шалгагдагч этгээдтэй байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.  |
|                               | (в) "Гэрээ" гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маяг болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.  |
|                               | (г) "Хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ.   |
|                               | (е) "Гэрээ хүчин төгөлдөр болох огноо" гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.   |
|                               | (д) "Гэрээний үнэ" гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.   |
|                               | (е) "ГЕН" гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.  |
|                               | (ё) "Гишүүн" гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг "Гишүүд" гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ. /Хэрэв байгаа бол/  |
|                               | (ж) "Гэрээний тал гэж" Захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн аль нэгийг, харин "Талууд" гэж оролцогчдыг нь хэлнэ.  |
|                               | (з) "Нэхэн төлөх зардал" гэж Гүйцэтгэгчийн ажлын хөлснөөс бусад үйл ажиллагаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.   |
|                               | (л) "ГТН" гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.  |
|                               | (м) "Үйлчилгээ" гэж Ажлын даалгаварт тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.   |
|                               | (о) "Туслан гүйцэтгэгч" гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.   |
|                               | (ө) "Ажиллах хүчин" гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.  |
| 1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль | Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.  |
| 1.3 Гэрээнд ашиглах хэл       | Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.  |
| 1.4 Мэдэгдэл                  | Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой. |

|     |  |  |
|-----|--|--|
| 1.5 | Байршил                                | Үйлчилгээг ажлын даалгаварт заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстай.  |
| 1.6 | Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ | Гүйцэтгэгч нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.   |
| 1.7 | Итгэмжлэгдсэн төлөөлөгч                | Гэрээний дагуу захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.  |
| 1.8 | Татвар, хураамж                        | Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстай.  |
| 1.9 | Авлигат болон залилан мэхлэх үйлдэл    | Захиалагчийг төлөөлөн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон шалгаруулалтад оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч Гүйцэтгэгч бүр сонгон шалгаруулалтад оролцох, гэрээ хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстай.<br><br>Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон оролцогч шинжээч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигат, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сурдуулэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ. |

## 2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

|     |                                       |   |
|-----|---------------------------------------|---|
| 2.1 | Гэрээ хүчин төгөлдөр болох            | Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.  |
| 2.2 | Үйлчилгээг эхлэх                      | Гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстай.  |
| 2.3 | Гэрээний хугацаа дуусгавар болох      | ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш талууд гэрээг дүгнэж дуусгавар болгоно.  |
| 2.4 | Гэрээний өөрчлөлт буюу засвар         | Гагчхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзول болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.  |
| 2.5 | Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл | <p>2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.</p> <p>2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Гүйцэтгэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн</p> |

болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

## 2.6 Гэрээ цуцлах

- 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
  - (б) Гүйцэтгэгч (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дамлуурулаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
  - (в) Гүйцэтгэгч нь сонгон шалгаруулалтад оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авлигат, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
  - (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон;
  - (д) Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:
- 2.6.2 Шинжээчийн санаачилгаар гэрээг цуцлах Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй
- (а) Захиалагч нь ГЕН-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг Гүйцэтгэгчийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй;
  - (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:

## 3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

### 3.1 Ерөнхий зүйл

- 3.1.1 Гүйцэтгэлийн чанар Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Гүйцэтгэгч нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн Гүйцэтгэгчийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэг буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

Төрийн аудитын болон шалгагдагч этгээд байгууллага, түүний ажилтнуудтай харьцах ёс зүйг чанд мөрдөж ажиллах, тэдгээрийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.

Төрийн аудитын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг нь гэрээгээр ажил гүйцэтгэж буй

|     |   |   |
|-----|---|---|
|     |   | шинжээч аудитын хуулийн этгээд болон түүний ажилтнуудад нэгэн адил үйлчилнэ.  |
| 3.2 | Ашиг сонирхлын зөрчил   | Гүйцэтгэгч нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.   |
| 3.3 | Нууцлал   | Гүйцэтгэгч, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсаа мэдээллийг аливаа этгээдэд дамжуулах, үйлчилгээний үр дүн, түүнд хамаарах аливаа баримт, тайлан мэдээг нийтэд нээлттэй болгох эрхгүй бөгөөд хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.                                |
| 3.4 | Гүйцэтгэгчийн хариуцах даатгал                                  | Гүйцэтгэгч нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзлын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.  |
| 3.5 | Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа      | Гүйцэтгэгч нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:   |
|     | (а)   | Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,   |
|     | (б)   | Гүйцэтгэх ажилд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.  |
|     | (в)   | ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа  |
| 3.6 | Тайлгнах хуваарь  | Гүйцэтгэгч нь тайлан гаргах хуваарьт заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.   |
| 3.7 | Шинжээчийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь | Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж Гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ.  |
| 3.8 | Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит               | Цэтгэгч нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.   |
|     |   | <b>4. ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖИЛТНУУД</b>   |
| 4.1 | Ажиллах хүчиний тодорхойлолт                                    | Гүйцэтгэгчийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарьт тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтад багтаана.       |
| 4.2 | Ажилтныг халах буюу солих                                       | (а) Захиалагч зөвшөөрөгүй бол ажиллах хүчиний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Гүйцэтгэгчийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ. |
|     | (б)   | Аль нэгэн ажилтан үргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр   |

гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрөхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстай.

- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсэж болох ямар нэгэн нэмэлт зардлыг гүйцэтгэгч нэхэмжлэх эрхгүй болно.

## 5. ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭДИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

|     |   |  |
|-----|---|--|
| 5.1 | Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох                           | Захиалагч нь ГТН-д заасан шинжээчид үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг олгуулахын тулд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.   |
| 5.2 | Гэрээнд хэрэглэх хуульд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт | Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуульд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Гүйцэтгэгчийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстай. |

## 6. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨЛӨХ ТӨЛБӨР

|     |                             |   |
|-----|-----------------------------|---|
| 6.1 | Нийт төлбөр                 | Гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрийн хэмжээ нь ажлын даалгаварт тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчилснээс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно. |
| 6.2 | Гэрээний үнэ                | (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.<br>(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.   |
| 6.3 | Нэмэлт үйлчилгээний төлбөр  | ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг гаргаж захиалагчаас зөвшөөрөл авна.  |
| 6.4 | Төлбөр хийх нөхцөл. хуваарь | Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан Гүйцэтгэгчийн дансанд хийнэ.<br>ГТН-д заасан нөхцөл болзлыг хангасны дараа, Гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстай.  |

## 7. ШУДАРГА БАЙДАЛ

|     |                |  |
|-----|----------------|--|
| 7.1 | Шударга байдал | Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биений эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна. |
|-----|----------------|--|

## 8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

|     |                                 |  |
|-----|---------------------------------|--|
| 8.1 | Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх | Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтад ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө.<br>Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. |
| 8.2 | Маргааныг шийдвэрлэх            | Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.   |

## 9. БУСАД

- 9.1 Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой талуудын эрх үүрэг
- Энэхүү гэрээг захиалагч, гүйцэтгэгч, шалгагдагч этгээд гурван тал баталгаажуулж гарын үсэг зурах бөгөөд талууд холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## II. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

|                        |   |
|------------------------|---|
| ГЕН-ийн зүйлийн дугаар | Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцэх, нэмэлт оруулах буюу өөрчилнэ.   |
| {1.1(a)}               | Гэрээнд хэрэглэх хууль нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж дүрэм, журам болон стандарт.  |
| 1.3                    | Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.   |
| 1.4                    | <p><u>Захиалагч:</u> Үндэсний Аудитын газар</p> <p>Захиалагчийн хаяг: Үндэсний Аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр</p> <p>Харилцах хүн: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш <a href="mailto:tsendayushn@audit.gov.mn">tsendayushn@audit.gov.mn</a>. Ажлын утас 263533. Гар утас: 88051068 ]</p> <p><u>Гүйцэтгэгч:</u><br/>Харилцах хүн: /нөхөх/<br/>Факс: /нөхөх/<br/>И-мэйл: /нөхөх/</p> |
| {1.6}                  | {Төлөөлөх эрх бүхий этгээд[нэрийг оруул]/Захирлын нэр, шууд захирагчийн нэр/ <u>Тэмдэглэл:</u> Гүйцэтгэгч нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд ГТН-ийн 1.5-д байгаа хаягийг энд оруулна. Гүйцэтгэгч дангаар оролцож байгаа бол ГТН-ийн энэ зүйлийг бүхэлд нь хасна.  |
| 1.7                    | <u>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</u> Захиалагчийн: : Аудитын хоёрдугаар газрын Аудитын менежер Д.Энхдалай. Ажлын утас: 260 512, гар утас: 99017209   |
| 1.8                    | Гүйцэтгэгч нь хууль журмын дагуу татвар, төлбөр, хураамжийг өөрөө хариуцна.   |
| {2.1}                  | Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: Гэрээнд оролцогч талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.   |
| 2.2                    | Үйлчилгээ эхлэх хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс гүйцэтгэгч ажлыг эхэлсэнд тооцно.  |
| 2.3                    | Гэрээний дуусгавар болох хугацаа: Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 22 хоногийн хугацааг хамарна.   |
| 3.4                    | Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь: Гэрээний туршид Мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байна.  |
| {3.5 (в)}              | {Бусад үйл ажиллагаа : Захиалагч гүйцэтгэсэн ажилд чанарын хяналт хэрэгжүүлнэ.}   |
| 6.2(б)                 | Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>Нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний үнэ байна. Гэрээний үнэд тохишуулга хийж болохгүй.</i>   |
| 8.2                    | Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхийн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.   |